



Тайлангийн бүтэц, агуулга

1. Сургалтын бэлтгэл ажлын хүрээнд
2. Сургалтын зохион байгуулалтын хүрээнд
3. Сургалтын үр дүн, цаашид анхаарах асуудлын талаар

НЭГ. СУРГАЛТЫН БЭЛТГЭЛ АЖЛЫН ХҮРЭЭНД:

Тус сургалтыг Монгол Улсын Эрүүл хотууд, Эрүүл хотын сүлжээний гишүүн, энэ чиглэлийн асуудлыг хариуцаж буй эрүүл мэндийн салбарын удирдах ажилтнууд, координаторууд, ажил хариуцаж буй хүмүүст зориулсан олон нийтийн эрүүл зан үйлийг дэмжих, чиглүүлэх зөв стратеги, Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллага (ДЭМБ)-ын энэ чиглэлээр баримталж буй аргачилсан заавраар хангах зорилгоор Эрүүл мэндийн яам, ДЭМБ, Нийгмийн эрүүл мэндийн төв, Эрүүл Хот хөтөлбөрийг чадавхижуулах төв (Эрүүл Хотуудын сүлжээ) зэрэг байгууллагууд хамтран батлагдсан удирдамж, төсвийн дагуу 2019 оны 6 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулав. Энэ удаагийн сургалтыг ДЭМБ-ын дэмжлэг, техник туслалцааны хүрээнд амжилттай хийлээ.

Зохион байгуулагч нарын хариуцсан ажлын чиглэл:

- Эрүүл Мэндийн яам
Тус яам нь оролцогчдод зориулсан урилгын албан бичиг гаргах, хөтөлбөрийн агуулга гаргах, сургалтын үеэр зарим үйл ажиллагааг удирдах үүрэг хүлээж ажиллалаа.
- ДЭМБ
Сургалтын үйл ажиллагааг санхүүжүүлж ажиллахын зэрэгцээ техникийн туслалцаа, сургагч багш нараар хангаж, удирдлага зохион байгуулалтын хувьд чиглүүлж ажиллалаа.
- Нийгмийн Эрүүл Мэндийн үндэсний төв

Сургалтад оролцогчдод Монгол улсын хүн амын архи, тамхины зохисгүй хэрэглээ, эрүүл зөв хооллолт, хөдөлгөөний дутагдал өнөөгийн байдал, цаашид хийж хэрэгжүүлэх ажлуудыг сэдэвчлэн тус бүр 10-15 минутын хичээл бэлтгэж сургалтад оролцогчдод мэдлэг, мэдээлэл олгов. Мөн сургалтын баннер, стендны эх бэлтгэж хэвлүүлэх, сургалтын тараах материалын флашны эх бэлтгэж хэвлүүлэх, үдийн зоог, цайны завсарлагаар хангах үйл ажиллагааг зохион байгуулав. Мөн сургалтын өдрүүдэд бүртгэлийн хуудсыг бэлтгэн, бүртгэлийг хийж, багуудын хувиарлалтад чиглүүлж, оролцогчдод томилолт, унааны зардлыг олгох, санхүүгийн тайланг хүлээлгэн өгөх ажлыг хариуцан ажиллалаа.

- Эрүүл Хот хөтөлбөрийг чадавхижуулах төв

Сургалтын гарын авлага материал, тавигдах илтгэлүүдийг англи хэлнээс монгол хэл рүү орчуулсан ба тухайн тараах материалуудыг олшруулж бүлгийн ажлын үеэр тараах, 5 Эрүүл хотын сайн туршлагын видео материалыг бэлтгэх, сургалтын сэтгэл ханамжийн судалгааг авах, сургалтын нэгдсэн тайлан гаргах, бүлгийн ажлын үеэр чиглүүлэгчээр ажиллах, зарим сургалтын үеэр удирдах зэрэг ажлыг хариуцан хийв.

Сургалтанд оролцогчдын хүрээ:

Сургалтын үйл ажиллагаанд Эрүүл хотуудын сүлжээний гишүүн болох 10 хот, тухайлбал,

- Дорноговь аймгийн Сайншанд хот,
- Хэнтий аймгийн Чингис хот,
- Өмнөговь аймгийн Даланзадгад хот,
- Дорнод аймгийн Чойбалсан хот,
- Дархан-Уул аймгийн Дархан хот,
- Орхон аймгийн Эрдэнэт хот,
- Говь-алтай аймгийн Алтай хот,
- Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хот,
- Баянхонгор аймгийн Баянхонгор хот,
- Хөвсгөл аймгийн Мөрөн хот,

Нийслэл Улаанбаатар, түүний дүүргүүд болох Сүхбаатар, Чингэлтэй, Багануур, Багахангай, Налайх, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэг зэрэг 9 дүүргийн Засаг дарга, Хотжилт ба эрүүл мэнд үндэсний хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн, Нийслэл, дүүрэг, аймгийн эрүүл мэндийн газар, төвүүдийн дарга, мэргэжилтэн нийт 78 хүнийг оролцуулж, чадавхийг бэхжүүллээ.

“ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ЗАН ҮЙЛИЙН ӨӨРЧЛӨХ СУРГАЛТ”-ЫН ТАЙЛАН

2019 оны 5 дугаар сарын 29-ны өдөр сургалтанд оролцох тухай албан бичгийг холбогдох газруудад Эрүүл мэндийн яамаар дамжуулан хүргүүлээ.



ХААНДАТ 1

Хотын хот амын эрүүл мэндийг дэмжих болон зан үйлийн өөрчлөлтөөр нэгдэж бус өөний урьдчилан сэргийлэлтийг сайжруулах зорилготой сургалтыг зохионо.

№	Агуулгын нэвс	Сургалтад оролцох хүний тоо		
		Амжилт-засаг дараа Хотын амьдрал	Эрүүл хотын үзүүлэлт хариуцах өргөжин-хөгжөөдөг	Амжилт-Зууны үзүүлэлт
1	Сайншид	1	1	1
2	Чинс	1	1	1
3	Арайхэр	1	1	1
4	Чойбалсан	1	1	1
5	Алтай	1	1	1
6	Сэлэнгэ	1	1	1
7	Баянхонгор	1	1	1
8	Мөрн	1	1	1
9	Дархан-Уул	1	1	1
10	Баянхонгор	1	1	1
	Нийт	10	10	10



ХААНДАТ 1

Хотын хот амын эрүүл мэндийг дэмжих болон зан үйлийн өөрчлөлтөөр нэгдэж бус өөний урьдчилан сэргийлэлтийг сайжруулах зорилготой сургалтыг зохионо.

№	Дундур	Сургалтад оролцох хүний тоо	
		Дундурин засаг дараа	Эрүүл хотын үзүүлэлт хариуцах өргөжин-хөгжөөдөг
1	Сүхбаатар	1	1
2	Баянхонгор	1	1
3	Чягартай	1	1
4	Сэлэнгэ	1	1
5	Ховд	1	1
6	Баянгол	1	1
7	Баянхонгор	1	1
8	Баянхонгор	1	1
9	Ховд	1	1
	Нийт	9	9

Улмаар Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Эрүүл Хот хөтөлбөрийг чадавхижуулах төвөөс холбогдох бүртгэлийг хийж, 78 оролцогчийг зохион байгуулалтаар ханган ажиллав.

Сургалтын хөтөлбөрийн талаар:

Сургалтын хөтөлбөр дараах хэсгүүдээс бүрдэж, тухайн илтгэл тавигч нарын илтгэл мэдээллийг бэлтгүүлэн хамтран ажиллав.

- 1) Нээлтийн үйл ажиллагаа
- 2) Эрүүл Хот хөтөлбөр, санаачлага, үр дүн, туршлага
- 3) Монгол Улс дах Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа
- 4) Эрүүл мэндийг дэмжих олон нийтийн зан үйлийг өөрчлөх хандлага, компани ажлыг удирдах арга барил, ур дүй аргачилсан заавар
- 5) ДЭМБ-ын Номхон далайн баруун эргийн бүсийн эрүүл хотын сайн туршлага, бодлого, үйл ажиллагаа гэсэн хэсгүүдээс бүрдэн 3 өдрийн нийт 23 цагийн сургалт хийв.

Мөн хөтөлбөрийг англи, монгол хэл дээр бэлтгэн ажиллаа.

Сургалтын илтгэгчид, сургагч багш нарын талаар:

- Эрүүл мэндийн яамны Хяналт шалгалт, дотоод аудитын газраас – Эрүүл хотуудын бодлого ба Хотын эрүүл мэндийн үнэлгээний тайланг хэлэлцүүлэхээр,

- ДЭМБ-аас ДЭМБ-ын зөвлөх Рийта Мажия Хамалайнэн, Мич Мижарес Мажини, Аника Синх нар сургалтын сургагч багшаар,
- НЭМҮТ-өөс Монгол Улс дах биеийн тамирын дасгал хөдөлгөөн, Монгол Улс дах эрүүл хоололт, Тамхи татахгүй байх, архины хортой бус хэрэглээ сэдвээр илтгэл танилцуулахаар,
- Эрүүл Хотуудын Сүлжээнээс Монгол Улс дах Эрүүл хот үйл ажиллагааны тайлан мэдээллийг танилцуулахаар,
- Нийслэлийн Засаг даргын тамгын газар – Улаанбаатар хот дах Эрүүл Хот хөдөлгөөн илтгэл хэлэлцүүлэхээр
- Чингис хот – Архигүй эрүүл хот сайн туршлага,
- Даланзадгад хот – Биеийн тамирын дасгал хөдөлгөөний талаарх хотын сайн туршлага,
- Чойбалсан хот – Эрүүл орчин бүрдүүлж буй сайн туршлага,
- Дархан хот – Салбар дундын хамтын ажиллагааг дэмжиж буй сайн туршлага,
- Сайншанд хот - Тамхигүй хот төсөлт үйл ажиллагааны сайн туршлагаа тус тус видео шторк байдлаар танилцуулахаар бэлтгэлийг хангав.

Сургалтын багуудын хуваарилалт:

Сургалтын үйл ажиллагааг илүү үр өгөөжтэй, хүртээмжтэй байх үүднээс оролцогчдыг багуудад хуваарилан, тухайн багийн ажлаараа дамжуулан өөрийн хот, дүүрэгтээ тодорхой эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр, төслийг удирдах арга зүйг эзэмшүүлэхийг зорилоо. Энэ үүднээс дараах 8 багт хувааж, харилцан туршлага, мэдээлэл, мэдлэгийг солилцууллаа.

Сургалтын бусад зохион байгуулалтын хүрээнд:

- Сургалт болох байр танхимыг судлан эхний өдрийн сургалт ЭМЯ-ны хурлын зааланд болсон бол сүүлийн хоёр өдрийн сургалтыг Хөвсгөл нуур зочид буудлын хурлын зааланд зохион байгуулав.
- Сургалтын үйл ажиллагааг аль болох ДЭМБ-ын “Эрүүл” уулзалт, хурал зохион байгуулах бодлого үйл ажиллагаатай нийцүүлжээ. Тухайлбал: цайны завсарлагаанаар аль болох эрүүл хоололтыг дэмжсэн байдлаар жимсний шүүс, жимсний цуглуулга, бүхэл үрийн гурилаар хийсэн, чихэр багатай нарийн боовоор хангалаа. Сургалтын үеэр 2 цагийн завсарлагатайгаар байнгын дасгал хөдөлгөөн хийж байв. Мөн цаасны хаягдал бага гаргах үүднээс олшруулах материал 10 ширхэг хэвлэж, улмаар бүхий л гарын авлага материалыг флашанд хуулж, оролцогчдод хүргэлээ.



- Үдийн зоогийг эхний өдөр Блю Скай зочид буудалд зохион байгуулсан бол сүүлийн 2 өдрийг Хөвсгөл нуур зочид буудалд зохион байгуулж, аль болох эрүүл хоололтын меню бүхий хоол захиалж, оролцогчдыг хангаж ажиллалаа.
- Сургалтын үеэр хэрэглэгдэх бичиг хэргийн материалыг бэлтгэж, тухай бүр оролцогчдод өглөө.
- Өдөр бүр НЭМҮТ-өөс 7 хүн, Эрүүл хотуудын сүлжээнээс 3 хүн сургалтын зохион байгуулалт, багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллалаа.
- Сургалтын үйл ажиллагааг гадаадын сургагч багш нар удирдан явуулсантай холбогдуулан англи-монгол хэлний мэргэшсэн сайн орчуулагчийг олж, хамгийн боломжит үнээр ажиллуулав.
- Сургалтын баннер, стендүүдийг хийж, цаг тухайд нь байршуулав.
- Сургалтанд оролцогчдод мэдээллээр тогтмол ханган хамтран ажиллалаа.
- Оролцогчдод олгох сертификатыг бэлтгэн, шаардагдах тоо хэмжээгээр хэвлэж бэлтгэв.

ХОЁР: СУРГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД



Монгол Улсын Эрүүл хотууд, Эрүүл хотын сүлжээний гишүүн, энэ чиглэлийн асуудлыг хариуцаж буй эрүүл мэндийн салбарын удирдах ажилтнууд, координаторууд, ажил хариуцаж буй хүмүүст зориулсан Эрүүл мэндийг дэмжих зан үйлийг өөрчлөх сургалтыг 2019 оны 6 дугаар

сарын 10-12-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулав.



Сургалтын үйл ажиллагааг нээж Эрүүл мэндийн дэд сайд Л. Бямбасүрэн үг хэлсэн ба тэрээр хэлсэн үгэндээ “... Эрүүл мэндийн салбарын ажил бол өвчнийг анагаах гэхээс илүүтэй урьдчилан сэргийлэх, нэн ялангуяа салбар дундын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд онцгой анхаарах хэрэгтэй юм” гэж онцлон тэмдэглэв.



ДЭМБ-ын Монгол дах суурин төлөөлөгч Сергей Диордица сургалтын нээлтэнд зориулж хэлсэн үгэндээ “... хотжилтоос үүдэлтэй хүн амын эрүүл мэндэд тулгамдаж буй асуудал зөвхөн Монгол улсад төдийгүй дэлхийн бүхий л улс оронд тулгамдсан асуудлын нэг байдаг. Ийм ч учраас НҮБ-аас хотжилт, эрүүл мэндтэй холбоотой тодорхой зорилт үйл ажиллагааг Тогтвортой

хөгжлийн зорилтод тусгасан. Мөн энэхүү зорилтыг хэрэгжүүлэхэд эрүүл мэндийн тэгш

“ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ЗАН ҮЙЛИЙН ӨӨРЧЛӨХ СУРГАЛТ”-ЫН ТАЙЛАН

байдлыг үнэлэх, хяналт зохицуулалтын хамгийн зөв, оновчтой арга хэрэгсэл нь болдог “Хотын эрүүл мэндийн тэгш байдлын индекс”-ийг хэрэглэх асуудал юм.” гэв.



Нэг. Сургалтын үйл ажиллагаа Эрүүл мэндийн яамны Хяналт шалгалт, дотоод аудитын газрын мэргэжилтэн С. Энхжин “Эрүүл мэндийн бодлого ба эрүүл мэндийн үнэлгээний тайлан”-г хэлэлцүүлж, улмаар тус үнэлгээний арга аргачлалын үр нөлөөг нэмэгдүүлэх, Монгол Улсын хотуудад хэрэгжүүлж эхлэх нэн

шаардлагатай байгаа талаар дурдав.



Хоёр. Мөн Эрүүл Хот хөтөлбөрийг чадавхижуулах төв, Монголын Эрүүл Хотуудын сүлжээний захирал Др. Ш. Цэрэндулам “Монгол Улсад өрнөсөн Эрүүл хот санаачлага, түүний бодлого, үйл ажиллагаа”-ны талаар илтгэл тавьж хэлэлцүүлээ.




Гурав. ДЭМБ-ын зөвлөх Рийта Мажия Хамалайен “Номхон далайн баруун эргийн бүсийн эрүүл хотууд” сэдвээр илтгэл тавьлаа. Тэрээр илтгэлийнхээ үеэр ДЭМБ-ын эрүүл мэндийг дэмжих 3 зарчмын нэг нь хотжилтоос үүдэлтэй бий болсон хотын эрүүл мэндийг дэмжих ба энэ нь бидний үйл ажиллагааны нэн тэргүүний зорилт болоод байгааг тэмдэглэсэн юм.



мэдээлэл хийлээ.

Улаанбаатар хотын хувьд сүүлийн жилүүдэд Эрүүл, Аюулгүй байдлын индексийг хэрэглэж хэвшсэнээр хотын хөгжлийг дэмжихэд маш үр дүнтэй байгаа талаар танилцууллаа.



Тав. Сургалтын үйл ажиллагаа 6 хэсгээс бүрдсэн ба үүнд:

- Яагаад зан үйлийг өөрчлөх хэрэгтэй гэж?
- Зан үйлийн өөрчлөлтийн харилцааг хөгжүүлэх үйл явц
- Харилцааны стратеги
- Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах нь
- Мониторинг ба үнэлгээ зэрэг болно.

Эдгээр хэсгүүдийн ойлголтыг өгөх үүднээс дараах 8 багт хуваарилан баг тус бүр өөрсдийн эрүүл мэндийг дэмжих харилцааны стратегиа боловсруулан ажиллав. Багийн хуваарилалтын дагуу,

Баг 1: Сайншанд хотын ЗДТГ, Эрүүл мэндийн газар, Нийслэлийн Сүхбаатар дүүргийн ЗДТГ, Эрүүл мэндийн төв

Чиглүүлэгч: Эрүүл Хотуудын сүлжээний захирал Ш. Цэрэндулам

Баг 2: Чингис хотын ЗДТГ, Эрүүл мэндийн газар, Нийслэлийн Баянзүрх дүүргийн ЗДТГ, Эрүүл мэндийн газар

Чиглүүлэгч: Эрүүл Хотуудын сүлжээ Ж. Түвшинбаяр

Баг 3: Даланзадгад хотын ЗДТГ, Эрүүл мэндийн газар Нийслэлийн Чингэлтэй дүүргийн ЗДТГ, Эрүүл мэндийн газар

Чиглүүлэгч: НЭМҮТ-ийн мэргэжилтэн А.Ононгоо



“ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ЗАН ҮЙЛИЙН ӨӨРЧЛӨХ СУРГАЛТ”-ЫН ТАЙЛАН



Эрүүл мэндийн газар, Нийслэлийн Налайх, Баянгол дүүргүүдийн ЗДТГ, Эрүүл мэндийн газрууд


Чиглүүлэгч: НЭМҮТ-ийн ТЗШУА-ны дарга Р.Даваадорж

Баг 7: Баянхонгор хотын ЗДТГ, Эрүүл мэндийн газар, Дархан хотын ЗДТГ, Эрүүл мэндийн газар, Нийслэлийн Багануур дүүргийн ЗДТГ, Эрүүл мэндийн газар

Чиглүүлэгч: НЭМҮТ-ийн Эрдэм шинжилгээний ажилтан Д.Сувд

Баг 8: Мөрөн хотын ЗДТГ, Эрүүл мэндийн газар, Эрдэнэт хотын ЗДТГ, Эрүүл мэндийн газар, Нийслэлийн Багахангай дүүргийн ЗДТГ, Эрүүл мэндийн газар

Чиглүүлэгч: НЭМҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан Д.Золзаяа нар тус тус хуваарилагдан ажиллав.



Баг 4: Чойбалсан хотын ЗДТГ, Эрүүл мэндийн газар, Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ, Эрүүл мэндийн газар

Чиглүүлэгч: НЭМҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан Д.Оюунчимэг

Баг 5: Алтай хотын ЗДТГ, Эрүүл мэндийн газар, Нийслэлийн Хан-Уул дүүргийн ЗДТГ, Эрүүл мэндийн газар

Чиглүүлэгч: НЭМҮТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан С.Сувд

Баг 6: Сүхбаатар хотын ЗДТГ,




“ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ЗАН ҮЙЛИЙН ӨӨРЧЛӨХ СУРГАЛТ”-ЫН ТАЙЛАН


Зургаа. Хотуудын сайн туршлага солилцоо

Эрүүл хотын сайн туршлага, загвар болон хөгжиж байгаа зарим хотууд өөрсдийн онцлог ажлаасаа танилцуулах видео шторкыг бэлтгэн оролцогч нарт танилцуулж, харилцан туршлага солилцлоо. Тухайлбал,

- Чингис хот – Архигүй эрүүл хот сайн туршлага,
- Даланзадгад хот – Биеийн тамирын дасгал хөдөлгөөний талаарх хотын сайн туршлага,
- Чойбалсан хот – Эрүүл орчин бүрдүүлж буй сайн туршлага,
- Дархан хот – Салбар дундын хамтын ажиллагааг дэмжиж буй сайн туршлага,
- Сайншанд хот - Тамхигүй хот төсөлт үйл ажиллагааны сайн туршлагаа танилцуулав.



Долоо. НЭМҮТ-ийн цахим сайтад сургалтын үйл ажиллагааны талаар мэдээлэл бэлтгэн байршууллаа



“ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ЗАН ҮЙЛИЙН ӨӨРЧЛӨХ СУРГАЛТ”-ЫН ТАЙЛАН



Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

June 12 · 🌐

Чойбалсан хотод эрүүл хот байхын төлөө хийж хэрэгжүүлж байгаа ажлын видео тайланг хүргэж байна. Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж байгаа "Хотын хүн амын эрүүл мэндийг дэмжих болон зан үйлийн өөрчлөлтөөр халдварт бус өвчний урьдчилан сэргийлэлтийг сайжруулах" сургалтад Чойбалсан хотын төлөөлөл идэвхтэй оролцож, шинэ мэдлэг, м... See More



👍 5

2 Comments 14 Shares 657 Views



Like



Comment



Share




Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

June 12 · 🌐

"Хотын хүн амын эрүүл мэндийг дэмжих болон зан үйлийн өөрчлөлтөөр халдварт бус өвчний урьдчилан сэргийлэлтийг сайжруулах" сэдэвт сургалтад Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хоол судлалын албаны ЭША Б.Энхтунгалаг эрүүл, зөв хооллолт сэдвээр, Эрүүл мэндийг дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх албаны ЭША П.Ундармаа архи, согтууруулах... See More



Найм. Сургалтанд оролцогчдын гарын авлага тараах материалыг тарааж ажиллалаа.



Ес. Сургалтын төгсгөлд оролцогч нарт сертификат гардуулсан ба үнэлгээний хуудсыг оролцогч нараас авч, цаашид сургалтанд анхаарч ажиллах асуудлаа тодотголоо. Тухайлбал, тус судалгаанд нийт 78 оролцогчоос 34 оролцогч хамрагдсан бөгөөд дараах байдлаар дүгнэсэн байна.

“ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ЗАН ҮЙЛИЙН ӨӨРЧЛӨХ СУРГАЛТ”-ЫН ТАЙЛАН



“ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ЗАН ҮЙЛИЙН ӨӨРЧЛӨХ СУРГАЛТ”-ЫН ТАЙЛАН

Д/д	Шалгуур үзүүлэлт	Өгсөн дундаж оноо /1-10 оноогоор/
Нэг. Сургалтын үйл ажиллагаа, зохион байгуулалтанд өгсөн оролцогчдын сэтгэгдэл		
1	Энэхүү сургалтан дах таны оролцоо ямар байсан бэ?	8.8
2	Сургалтын зохион байгуулалт ямар байсан бэ?	9.4
3	Сургалтын манлайлал ямар байсан бэ?	9.2
4	Сургалтын төлөвлөлт ямар байсан бэ?	9.3
5	Энэ уулзалтын материаллаг бааз ямар байсан бэ?	9.6
6	Энэ уулзалтын танхимын хувьд ямар байсан бэ?	9.6
7	Хурлын үеэр өгч байсан цайны завсарлага, үдийн зоогны зохион байгуулалт ямар байсан бэ?	9.6
8	Энэ хурлын талаархи таны сэтгэгдэл ямар байна вэ?	9.6
Хоёр. Сургалтын чанар, хүртээмжийн талаархи оролцогчдын ойлголт, сэтгэгдэл		
9	1 дүгээр хэсэг : <u>Танилцуулга+ Том зургаар: Яагаад зан үйлийн өөрчлөлтийн харилцаа гэж?</u>	
9.1	Энэ хэсгийн зорилтыг ойлгох	9.1
9.2	Санаа бодлоо хуваалцах болон хэлэлцүүлэгт мэдээлэл солилцох	9.3
10	2 дугаар хэсэг: <u>Зан үйлийн өөрчлөлтийн харилцааг хөгжүүлэх үйл явц</u>	
10.1	Энэ хэсгийн зорилтыг ойлгох	9.3
10.2	Санаа бодлоо хуваалцах болон хэлэлцүүлэгт мэдээлэл солилцох	9.4
11	3 дугаар хэсэг: <u>Харилцааны стратеги</u>	
11.1	Энэ хэсгийн зорилтыг ойлгох	9.4
11.2	Санаа бодлоо хуваалцах болон хэлэлцүүлэгт мэдээлэл солилцох	9.4
12	4 дүгээр хэсэг: <u>Харилцааны бүтээгдэхүүнүүдийг бий болгох болон шалгах</u>	
12.1	Энэ хэсгийн зорилтыг ойлгох	9.1
12.2	Санаа бодлоо хуваалцах болон хэлэлцүүлэгт мэдээлэл солилцох	9.1
13	5 дугаар хэсэг: <u>Дэлгэрэнгүй ажлын төлөвлөгөө хөгжүүлэх</u>	
13.1	Энэ хэсгийн зорилтыг ойлгох	9.3
13.2	Санаа бодлоо хуваалцах болон хэлэлцүүлэгт мэдээлэл солилцох	9.3
14	6 дугаар хэсэг: <u>Мониторинг болон Үнэлгээ</u>	
14.1	Энэ хэсгийн зорилтыг ойлгох	9.2
14.2	Санаа бодлоо хуваалцах болон хэлэлцүүлэгт мэдээлэл солилцох	9.1

ГУРАВ: СУРГАЛТЫН ҮР ДҮН, ЦААШИД АНХААРАХ АСУУДЛЫН ТАЛААР

ДЭМБ-ын зөвлөхүүдээр удирдуулсан сургалт байсан тул олон талын мэдээллийг нэг дор авах боломж нөхцлийг бүрдүүлсний зэрэгцээ ороцогчдын бүрэлдэхүүн өргөн хүрээтэй байснаараа онцлог байв.

Үр дүн 1: Эрүүл хотын үйл ажиллагааг дэмжин ажиллаж буй хот, орон нутгийн удирдлага, холбогдох асуудал эрхэлсэн мэргэжилтнүүд эрүүл мэндэд ээлтэй зан төлөвийн өөрчлөлтийг дэмжсэн үйл ажиллагааг урт болон богино хугацаанд төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, үнэлэх, нөлөөлөх чадавхитай боллоо.

Үр дүн 2: Эрүүл зан үйлийг дэмжих дотоодын болон гадаадын сайн туршлагатай танилцаж, өөрийн орон нутагтаа хэрэгжүүлэх санал санаачлагыг идэвхжүүллээ.

Цаашид анхаарах асуудал:

Нэг. Сургалтын зохион байгуулалтын хүрээнд:

1. Улаанбаатар хотоос оролцож буй оролцогчдын идэвх, оролцоо сул байсан тул цаашид анхаарах шаардлагатай.
2. Орчуулгын төхөөрөмж хүртээмжгүй байсан тул орчуулганд тодорхой хугацаа алдсан, гарын авлага олноор олшруулаагүй флашаар өгсөн тул оролцогчид хэвлэмэл материал шаардаж байлаа.

Хоёр. Цаашид хэрэгжүүлэх шаардлагатай ажлын талаар:

1. Тус сургалтын ач холбогдол, үр өгөөжийг үнэлэн сургалтын агуулга, материалыг ашиглан аймаг, хотуудын өөрийн орон нутагтаа авах хүсэлттэй байгаа тул үргэлжлүүлэн зохион байгуулах,
2. Эрүүл хот санаачлагад нэгдсэн сүлжээний гишүүн хотуудад орон нутгийн сайн туршлага дээр нь тулгуурлан сургалт семинар зохион байгуулах,
3. Монгол Улсын Эрүүл хотыг хөгжүүлэх аргачилсан заавар, сайн туршлага зэргийг нэгтгэсэн гарын авлагыг гаргаж, хотуудад түгээх зэрэг болно.

ХАВСРАЛТ:

- 1) Сургалтын хөтөлбөр
- 2) Сургалтанд оролцогчдын нэрсийн жагсаалт
- 3) Оролцогчдын үнэлгээний тайлан
- 4) Гарын авлага, тараах материал
- 5) Бусад холбогдох материал

**ЭРҮҮЛ ХОТ ХӨТӨЛБӨРИЙГ ЧАДАВХИЖУУЛАХ ТӨВ
/МОНГОЛЫН ЭРҮҮЛ ХОТУУДЫН СҮЛЖЭЭ/**